

ГАРЧИГ

1. ОРШИЛ	5
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1. Төслийн зорилго, хүчин чадал	6
2.2. Төслийн ерөнхий төлөвлөлт	6
2.3. Туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл	7
3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3.1. Уур амьсгал	8
3.2. Геоморфологи	8
3.3. Хөрс, Ургамлан бүрхэвч	9
3.4. Нийгэм, эдийн засаг	9
3.5. Төслийн талбайн байршил	10
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
4.1. Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц	11
4.2. Газрын гадарга, хэвлий	12
4.3. Агаарын чанар	13
4.4. Уур амьсгал	13
4.5. Гадаргын болон газрын доорх ус	13
4.6. Ургамлан нөмрөг	13
4.7. Амьтны аймаг	13
4.8. Тусгай хамгаалалттай газар нутаг	14
4.9. Дуу шуугиан	14
4.10. Нийгэм, эдийн засаг.....	14
4.11. Түүх, соёлын дурсгалт зүйлс	14
4.12. Хог хаягдлын менежмент	14
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	15
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15

6.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	15
6.1.1. Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах	15
6.2. Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	16
6.2.1. Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	16
6.2.2. Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих	16
6.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	18
6.3.1. Хог хаягдлын түр цэгт тогтмол хяналт тавьж ажиллах	18
6.3.2. Шимт хөрсний овоолгыг хадгалах	18
6.4. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ...	19
6.4.1. Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл	19
6.4.2. Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих	19
6.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	20
6.5.1. Кемп болон ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх	20
7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
7.1. Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамал тариалах	21
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
8.1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	21
8.1.1. Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	21
8.1.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
8.1.3. Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	22
8.1.4. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах ...	23
8.2. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	26

8.2.1. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	26
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
9.1. Ахуйн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр	27
9.1.1. Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	27
9.1.2. Дотоод, гадаад орчны хог цуглуулах савны стандартыг сайжруулах	27
9.2. Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр	28
9.2.1. Аюултай хог хаягдлын үүсгэгч болон аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар тусгай зөвшөөрөл авах	28
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	29
10.1. Агаарын чанарын хяналт шинжилгээ	
10.1.1. Гадаад орчны PM2.5, PM10 болон нийт тоосны хэмжилт	
10.1.2. Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	
10.1.3. Дуу чимээний хяналт	
10.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт, шинжилгээ	
10.2.1. Хөрсөн дэх хүнд металлын агууламж	
10.2.2. Агрохими	
10.2.3. Нянгийн бохирдол	
10.3. Усан орчны хяналт шинжилгээ	
10.3.1. Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	
10.3.2. Усны хүнд металлын шинжилгээ	
10.3.3. Микробиологийн шинжилгээ	
10.4. Ургамлан бүрхэвчийн хяналт, шинжилгээ	
10.4.1. Ургамлын мониторинг	
10.5. Амьтны аймгийн мониторинг	
10.5.1. Амьтны мониторинг	
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	31
11.1. Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх	31

11.2. Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	
11.3. Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	31
11.4. Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх	32
12. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
12.1. Сумын иргэдэд БОМТ-н биелэлт танилцуулах	
12.2. Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнүүдэд үйл ажиллагааг танилцуулах	
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
14. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР	
15. ХАВСРАЛТ	

НЭГ. ОРШИЛ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Өехий цагааны хүрэн нүүрсний орд”-ын батлагдсан ТЭЗҮ-ийн хүрээнд БОУАӨЯ-ны 2024 оны 09-р сарын 10-ны өдрийн 2024/БС-02 дугаар бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, БОНХС-ын (хуучин нэрээр) 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-05 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

БОННҮ-ний ажлын үр дүнд ашиглалт-олборлолт явуулах талбайд улсын комисс хүлээн авах бэлтгэл ажлын болон ашиглалтын үйл ажиллагааны үе дэх байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал, Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2025-2030 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээнүүд зэрэг асуудлуудыг байгаль орчны шалгууруудаар тодорхойлсон. Тайлан нь “Өехий цагаан”-ны ордын ашиглалт-олборлолтын үйл ажиллагаанд хамаарах тул “Эйкүсора” ХХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө.

ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн зорилго, хүчин чадал

“Өехий цагаан” хүрэн нүүрсний төсөл нь “Эйкүсора” ХХК-ийн 2025-2030 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтыг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний бүтээгдэхүүн бий болгох, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах зорилготой.


Хүрэн нүүрсний ордыг 2025 онд ашиглалт явуулахаар бэлтгэл ажил хийгдсэн бөгөөд ТЭЗҮ-ийн тусгагдсанаар эхний жилд 0.5 сая.тн, 2026 онд 1.0 сая.тн нүүрс олборлох хүчин чадлаар ажиллахаар төлөвлөсөн байсан.

1.2. Төслийн ерөнхий төлөвлөлт

“Өехий цагаан”-ны хүрэн нүүрсний орд нь MV-020423 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 4201011266, 4201011265 нэгж талбарын дугаартай газарт нийтдээ 1447.94 га талбайг хамаарна.

Уурхайн бүс нь дараах байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

- Уурхайн карьер /ухаш/:
- Шимт хөрсний овоолгийн талбай:
- Хөрсний гадаад овоолгийн талбай:
- Нүүрс цагаалгийн талбай /ром/:
- Автожингийн байр:
- Хог хаягдлын цэг:
- Туслан гүйцэтгэгч компаниудын барилга, байгууламж:
- Химийн бодис, шатах туслах материалын цэг:
- Аж ахуйн хэсгээс бүрдэнэ.



Зураг No 1. Төслийн талбайн ерөнхий дэвсгэр зураг /2025.04.01/

1.3. Туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүрэн нүүрсний ордын төслийн уурхайн комисс хүлээлгэн өгөхөд, бэлтгэл /хөрс хуулалт, нүүрсний тааз гаргах болон бусад шаардлагатай/ ажлуудыг гүйцэтгэхээр “Хишиг майнинг” ХХК болон “Си Чу Дэн Шин” ХХК-уудтай гэрээгээр ажилласан.

ГУРАВ. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Уур амьсгал

Ашиглалтын талбай нь хойд сэрүүн бүсийн эх газрын эрс тэс уур амьсгалтай, хуурай бүсэд байрлах ба хур тунадас бага, ууршилт ихтэй, чийг багатай хуурай дулаавтар мужид багтдаг. Агаарын температурын хоногийн зөрүү харьцангуй их бөгөөд хуурайшилтай, элсэн шуурга ихтэй. Өвөл нь хүйтэн, зун нь халуун, намар харьцангуй дулаан, хавар салхи ихтэй, хуурай. Хамгийн дулаан сар нь 7, 8 дугаар сар бөгөөд +32°C хүрч халдаг. Өвлийн улиралд нэлээд хүйтрэх бөгөөд 1, 2-р саруудад хамгийн хүйтэн буюу -32-35°C хэм хүрнэ.

Жилийн хур тунадасын хэмжээ бага. Жилд дунджаар 100 мм орчим хур тунадас унадагаас бороо голлоно. Цасны хэмжээ бага, 10 см-ээс ихгүй зузаантай цасан бүрхүүл тогтдог боловч огцом шуурч хунгарлах эсвэл эрт хайлж алга болдог.

Талбайн ууршилтын хэмжээ их, жил тус бүрийн ууршилт харилцан адилгүй. Жилийн дундаж ууршилтын хэмжээ 2882.9 мм, сар бүрийн ууршилтын хэмжээ маш их зөрүүтэй бөгөөд 5,6,7-р саруудад хамгийн их, 1-р сард хамгийн бага. Тус нутагт жилийн дундаж харьцангуй чийгшил 61.3%. Харьцангуй чийгшлийн хувьд өвөл 12-1 дүгээр сард хамгийн их, хаврын улиралд хамгийн бага байна.

Бүтэн жилийн турш салхи ихтэй ба хавар харьцангуй ширүүн салхитай. Салхины хурд ердийн үедээ 2-4 м/с. Богино хугацаанд 11 м/с -д хүрдэг бол хамгийн их үедээ 24-30 м/с -т хүрдэг байна. Өвлийн улиралд хамгийн бага салхины хурдны утга ажиглагдана. Өвөл, хаврын улиралд БХ чиглэлийн салхи давамгайлах бөгөөд зуны улиралд ЗӨ зүгийн салхи илүү байдаг. Харин намрын улиралд ЗӨ ба БХ зүгийн салхи ээлжлэн салхилдаг.

3.2. Гадаргын хэв шинж геоморфологи

Төв Азийн геоморфологийн мужийн Монголын өмнөд мужид хамаарагдана. Судалгааны талбайн 16 орчим хувийг түр зуурын урсгал усаар үүссэн сайрууд эл. Газрын гадаргуугийн гол хэв шинж нь намхавтар толгодорхог гүвээ ээлжлэх ба тэдгээрийн хооронд нам хотос хөндийнүүд нь Мезозой-Кайнозойн сул нягтаршсан чулуужиж амжаагүй нуурын их зузаантай тунамал (шавар, алевролит, элсэн чулуу, хайргархаг элсэрхэг хурдас) чулуулгуудаар дүүргэгдсэн байдаг. Рельефийн өндөршил нь гол төлөв 1200-1140 м хооронд хэлбэлзэх ба хамгийн

өндөрлөг уулархаг хэсэг нь судалгааны талбайн зүүн хэсгээр Чойрын богд уул далайн түвшнээс дээш 1676.5 м, мөн Халиуны цагаан өндөр далайн түвшнээс дээш 1337.8м-ийн хэлхээ уулууд нэлэнхүйдээ эзэлнэ. Эдгээр уулсаас баруун тийш бэл хормойноос нь эхлэн гадаргуу алгуур намсаж Сэвхүүлийн улаан нуурын тойром далайн түвшнээс дээш 1130 м-ийн хэсэг хамгийн нам цэг болно.

3.3. Хөрс, ургамлан бүрхэвч

Уг талбайд хээрийн хүрэн болон хүрэн цайвар шаварлаг хөрс ихээр, говийн элсэрхэг, бор, цайвар шаварлаг, хужирлаг хөрс ховроор тархсан.

Ургамлан нөмрөгийн хувьд говийн элсэрхэг, бор, цайвар шаварлаг хөрсөнд хазаар хялгана, ерхөг, агь, хөмүүл, таана, говирхог газраа дэрс, улаан, бор бударгана, төрөл бүрийн шарилжууд болон модлог ургамлаас алтан харгана, бор харгана голлон ургасан байх нь тааралдана. Булаг шанд бүхий газруудад өтгөн дэрс, зэгс, бударгана, таана, хөмүүл элбэг ургадаг.

Говийн бор хөрсний гадарга дээрх элс-сайр, чулуун хучаас хэдий зузаан биш (0.5-2.0см) ч гэсэн хөрсний дулааны горимд тодорхой хэмжээгээр нөлөөлж, хөрсний өнгөн хэсгийг хэт халалтаас хамгаалдаг онцлогтой. Хөрсний улирлын хөлдөлтийн гүн нь өвөл 1.6-2.5м хүрч түүнээс доош хасах температур үл ажиглагдана. Зундаа халуун, хуурай уур амьсгалтай байдгаас болж хөрсний өнгөн хэсэг, дээд үеүд хүчтэй халж, ургамлын үлдэгдлийн эрдэсжих үйл явц эрчимждэг.

Нутгийн хойд, зүүн хойд хэсгээр үржил шимт хүрэн хөрс, харин баруун, баруун урд талаараа элсэрхэг, хайрган хөрстэй, мөн хужиртай хонхор, тойром элбэг байдаг.

3.4. Нийгэм, эдийн засаг

Хүн амын хувьд Говьсүмбэр аймаг нь 14500 гаруй хүнтэй, 4300-аад айл өрх оршин суудаг. Аймгийн төв нь засаг захиргааны байгууллага, ахлах сургууль, сургуулийн дотуур байр, номын сан, соёлын төв, цэцэрлэг, хүн эмнэлэг, мал эмнэлэг, эмийн сан, зочид буудал, шатахуун түгээх станц, үүрэн телефоны Скайтел, Мобиком, Юнителийн хөдөлгөөнт холбоо, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн салбар, “Монгол шуудан” ХК-ийн шуудангийн салбар болон худалдаа үйлчилгээний байгууллагууд төвлөрдөг. Эдгээр нь цахилгаан эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, төвийн эрчим хүчний системд холбогдсон байна.

Ерөнхийдөө зам тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн төв бүсэд хамаарагдана. Улаанбаатараас Замын үүдийг чиглэсэн асфальтан замаар Чойр хот хүртэл, түүнээс цааш шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Орон нутгийн шинж чанартай шороон замаар тухайн талбайд аль ч талаас нь жилийн 4 улиралд хүрэх бүрэн боломжтой. Замын нөхцөл сайн гэж хэлж болно.

Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн олон улсын төмөр зам нь төслийн талбайн яг дундуур дайран гардаг бөгөөд энэ замаар олон улсын ачаа тээврийн болон хүн тээврийн галт тэрэг байнга явдаг. Чойр хотод Чойр өртөө байрлахаас гадна төслийн талбайд байрлах 21, 22 дугаартай зөрлөг дээр галт тэрэг түр зогсдог. Нисэх онгоц буух, хөөрөх тусгай талбайгүй. Талбайн гадаргуу тэгшивтэр тул нисэх онгоц бууж хөөрөх боломж сайтай гэж үздэг. Төслийн талбайг дайран өнгөрөх 35Кв-ын цахилгаан дамжуулах шугам, төмөр зам зэрэг нь дэд бүтцийг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байна.

3.5. Төслийн талбайн байршил

Монгол Улсын нутаг дэвсгэрийн төвийн бүсийн зүүн өмнөд хагаст, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос 230 км-т оршино. Харин ШивээОвоо төслийн талбай нь Говьсүмбэр аймгийн төв Чойр хотоос урагш 10 км-т байрлана.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ордыг ил аргаар ашиглах төслийн явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөг боловсруулах зорилгоор НҮБ-ын Ази Номхон далайн орнуудын нийгэм эдийн засгийн комиссын болон Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас гаргасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний заавар, гарын авлагыг ашиглан магадлан жагсаах аргаар голлох нөлөөллүүдийг тогтоож үнэлгээг гаргасан ба Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний Тайлан (цаашид БОННУ гэх)-д тусгасан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг баримталаа. БОННУ-д төслийн үйл ажиллагаанаас үүсэх болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд: Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;

- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Цаашид салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

MNS 6010:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт № 1. Эрсдэлийн үнэлгээний матриц

№	Аюул	Орчны шинжилгээ			Үр дагавар	Магадлал	Эрсдэл	Хувийн жин	
1	Уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед	1	Ордын геологийн тогтоц	Чулуулгийн төрөл, нягт, хатуулаг	3	3	9	Анхаар	
				Чулуулгийн хагарал, ан цавшилт					
				Ашигт млтмалын тогтоц, байрлал, хэлбэр, хэмжээ					
		2	Гидрогеологи	Гадаргын болон гүний усны нөлөө	3	3	9		
		3	Газарзүйн хүчин зүйл	Температурын өөрчлөлт, газар хөдлөлт	3	3	9		
		4	Уул техникийн хүчин зүйл	Олборлолтын арга технологи, ашиглалтын систем, дизайн	2	2	4		Хянах
		5	Уурхайн олборлолтын үед хүнд даацын машин техниктэй харьцах үед бэртэж гэмтэх		3	3	9		Анхаар
6	Олборлолт явуулсан газрын ухаш, нүхрүү унаж бэртэх, тээврийн хэрэгсэл осолдох		3	3	9				
7	Шороо нурангид даруулах		3	3	9				
2	Уурхайн замд техник, ажлын талбай болон овоолго замаас унах осол	1	Тоосжилт		4	3	12	Ноцтой	
		2	Дүрэм журмын зөрчил		5	3	15	Аюулт	
		3	Техникийн бүрэн бус байдал		5	2	10	Анхаар	
3	Усны цөмрөл, аюултай бодисын ялгарал	1	Уурхайн карьерт үерийн ус хамгаалах далан шуудуу татсан эсэх		3	3	9	Анхаар	
		2	Уурхай усанд автах, усны осол		3	3	9		
		3	Аюултай бодис, хорт хий ялгарах нөхцөл, хамгаалах арга хэмжээ		2	2	4	Хянах	

Хүснэгт № 2. Магадлалын үнэлгээний шалгуур

**“ӨЕХИЙ ЦАГААН”-НИЙ ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

			Магадлал				
			Байнга	Ер нь	Заримдаа	Ховор	Маш ховор
			A	B	C	D	E
Аюулд өртөх зэрэг	Гамшгийн хэмжээний	I					
	Ноцтой	II					
	Дунд	III					
	Яльгүй	IV					

Хүснэгт № 3. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

№	Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	Үр дагавар	Эрсдэлийн лелгөлөл	Хариу арга хэмжээ
1	Ажилчдын хотхон	Дулаан түгээх	Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Түлш зарцуулалтийн хяналт
		Их хэмжээний хог хаягдал	Лендфилийн талбай нэмэгдэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
				5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
2	Уурхайн бэлтгэл ажил	Хөрс хуулалтын ажил	Тоосжилт	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ
			Хөрсний эвдрэл	4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт
				4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт
3	Засвар, угсралт эрхлэлт	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана /дахин боловсруулах/	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт
				4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах
				4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг
		4		3	III	Аюултай бодисын удирдлага	
		4		3	III	Хөрсний бохирдлын хяналт	
		4		4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	
		4		4	IV	Хөрсний бохирдлын хяналт	

4.2. Газрын гадарга, хэвлий

Төслийн бэлтгэл ажлын үед шатах тослох материал алдагдах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс хог хаягдлаар бохирдох, газрын гадарга эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Талбай нь хойноосоо урагш уртрагийн дагуу сунаж тогтсон, хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөр, цав толгод, хөндий хотгор хосолсон, ерөнхийдөө долгиорхог тэгш гадаргатай.

4.3. Агаарын чанар

Төсөлд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр түр зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Ашиглах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд бага хэмжээгээр нөлөөлнө.

4.4. Уур амьсгал

Төслийн талбайд ашиглах техник хэрэгслүүдээс хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ.

4.5. Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед болон ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч шатах тослох материал асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсац болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

4.6. Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжүүлэх талбай, ашиглалт-олборлотын ажилд ашиглагдах түр зам, кемп байгуулах газрууд бүтээн байгуулалтын үед нөлөөлөлд өртөнө. Бүтээн байгуулалтын дараа “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-ний дагуу нөлөөлөлд өртсөн талбай, газруудыг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.7. Амьтны аймаг

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт дараах нөлөөлөл, үр дагаврууд бий болж болзошгүй. Төслийн үндсэн үйл ажиллагаа хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үүсэх магадлалтай. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах нөлөөлөл гарч болзошгүй. Төслийг хэрэгжүүлэх явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад олноор

шилжин суурьшиж болзошгүй тул амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх, амьтны төрөл зүйлийг сэргээхэд анхаарах шаардлагатай.

4.8. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй тул тэдгээр газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

4.9. Дуу шуугиан

Төслийн бүтээн байгуулалтын үед төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу шуугиан үүсч болзошгүй.

4.10. Нийгэм, эдийн засаг

Үйлдвэрийн бүс, овоолгын үйл ажиллагаанаа үүсэх тоосжилт төслийн талбайн ойролцоох нөлөөллийн бүсэд хамрагдах малчин өрх, байгаль орчинд нөлөөлөх магадлалтай. БОННУ-нд төслийн талбайгаас 3 км радиус дотор байгаа айлыг нөлөөллийн бүс гэж үзнэ гэж тусгасан.

4.11. Түүх, соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбай болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс өнөөгийн байдлаар тодорхойлогдоогүй. Энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

4.12. Хог хаягдлын менежмент

Түр кемп, төслийн талбайд ажиллаж буй туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас аюултай болон ахуйн хог хаягдлууд үүсч санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хаягдал асгарч алдагдсанаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй. Төслийн барилга, байгууламжуудын барилга угсралтын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх замаар үр ашигтай зохион байгуулж, бууруулж болно. Энэ нь төслийн байгаль орчны менежментийн чухал хэсэг болно.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Өехий цагаан”-ны хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад буюу 2025-2030 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. Мөн “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон уг төслийн БОННУ-г үндэс болгов.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

Төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон ашиглалтын үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт).

ЗУРГАА. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

6.1.1. Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах
Уурхайн үйл ажиллагаа 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 09 дүгээр сарын 30-ны байдлаар уурхайд нийт **38,120 м³** усыг зам усалгаа буюу тоосжилт дарах үйл ажиллагаанд ашигласан. Уурхайн питийн замын усалгааг аль болох ямар ч

тохиолдолд тоосжилт босохгүй байх тал дээр анхаарч ажилладаг. Уурхайн дотоод тээврийн 1 км замыг 1 машин усалгаа хийж ажиллаж байна. Нэг машин өдөрт дунджаар нийт 15 орчим км замын усалгааг хариуцан хийж байгаа.



Уурхайн усалгааны машин



Усалсаны дараах тоосжилт дарагдсан байдал



Уурхайн усалгааны дараах байдал



Усалгааны машин усалж байгаа байдал

6.2. Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр


6.2.1. Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах

Нийт 157 мян.м² талбай хөндөгдсөнөөс 1343000 м³ орчим уулын цулыг хөдөлгөж үүнээс 40 мян.м³ шимт хөрсний овоолго үүсгэсэн байна. Уулын ажлын өртсөн талбай, дэд бүтэц ба инженерийн ажлуудын хүрээнд хөндсөн бүх талбай орсон. 2024-2025 онд хуулсан шимт хөрсийг 1 овоолго дээр төвлөрүүлсэн.

6.2.2. Замын батлуулсан маршрутаар зорчих

Нүүрс тээвэрлэлт хийх үеэр Аймгийн удирдлагуудтай уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх гэрээ байгуулсан гэрээний дагуу тээврийн жолооч нарт батлагдсан маршрутаар зорчих зааварчилгаа өгч гарын үсэг зуруулна. Одоогийн байдлаар нүүрс тээвэрлэлт хийгдээгүй байна.

“ӨЕХИЙ ЦАГААН”-НИЙ ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН


ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Т. БАТ-ЭРДЭНЭ

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 10 дугаар сарын 02 -ны өдөр №..... Сүмбэр сум

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Гэрээгээр нэг талаас Говьсүмбэр аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж аймгийн Авто тээврийн төвийн дарга Н.Мөнхнаран (цаашид орон нутгийг төлөөлж) нөгөө талаас Зикүсора ХХК, түүнийг төлөөлж Б.Даваадорж (цаашид аж ахуй нэгжийг төлөөлж) нь Говьсүмбэр аймгийн нутагт ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд янгалт тавих, БНХАУ-с руу нүүрсний дээж гаргаж шинжилгээнд хамруулах зорилгоор дараах зүйлийг харилцан тохиролцож талуудын хүлээж хариуцлага, эрх үүргийг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Гэрээнд Монгол Улсын Иргэний хууль, Автотээврийн тухай хууль, Автозамын тухай хууль, Төрийн янгалт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, холбогдох бусад стандарт журмыг мөрдлөг болгоно.

1.3 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

1.3.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

1.3.2 Ачаа илгээж болон хүлээн авагчтай байгуулсан тээвэрлэлтийн гэрээ;

1.3.3 Орон нутгийн ачаа тээвэрлэлтийн чиглэл тогтоох тухай аймгийн Засаг даргын захиралмаар батлагдсан чиглэл/маршрут/ дагуух тээврийн хэрэгслийн хөдөлгөөний график зурвал, цагийн хуваарь;

1.3.4 Тээврийн хэрэгсэл болон жолоочийн албан журмын даатгал, ачааны даатгалд даатгуулсан байх /Даатгалын гэрээний хуулбарыг хавсаргах/;

1.3.5 Ажлын байр, удирдах албан тушаалтан, инженер техникийн ажилтан, жолооч болон тээврийн хэрэгслийн судалгаа;

1.3.6 Автотээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах засвар үйлчилгээний байгууламж, тээвэрлэлтийг гүйцэтгэх жолооч, бусад ажилчдыг байршуулах зориулалт бүхий өөрийн эсхүл түрээсийн байрны танилцуулга, холбогдох баримт бичгийн хуулбар;

1.3.7 Шаардлагагүй бол тээвэрлэлт гүйцэтгэх гадаадаас авах ажиллах хүчний тоо, эрх бүхий байгууллагаас олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг нотригаар гэрчлүүлсэн хуулбар;

1.3.8 Тээврийн хэрэгсэл бүр дээр орон нутгийн ачаа тээвэрлэлтэд тавигдах нэмэлт шаардлагыг хангаж буй тухай Автотээврийн Хяналтын Улсын байцагчийн дүгнэлт гаргуулах;

1.3.9 Тээвэрлэлтийг батлагдсан маршрутын дагуу хатуу хүчилтэй автозамаар гүйцэтгэхэд зам харуулагч компанитай байгуулсан гэрээ, шороон замаар

6.8 Автотээврийн Хяналтын Улсын байцагч, Засаг даргын албан шаардлагыг тодорхой бус шатгаанаар зөрсөн.

6.9 Тээвэрлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрсөн /3 буюу түүнээс дээш/.

6.10 Эрх бүхий байгууллагын шалгалтаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллаагүй.

7. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭГ ДҮГНЭХ

7.1 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө талдаа албан бичгээр санал гаргана.

7.2 Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд харилцан зөвшилцөн нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ байгуулна. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

7.3 Гэрээний үүргийн биелэлтийг талуудын оролцортой дүнх бөгөөд гэрээ дүгнүүлсэн байдлаас хамаарч, цаашид нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

7.4 Гэрээний үүргийн биелэлт хангаагүй тохиолдолд гэрээ цуцлах үндэслэл болно.

8. БУСАД

8.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарагдсанаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.

8.2 Гэрээг адил хүчинтэй 4 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

8.3 Талууд энэхүү гэрээтэй холбоотой маргаантай асуудал гарвал харилцан тохиролцож, зөвний журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН


ОРОН НУТГИЙГ ТӨЛӨӨЛЖ
 СНИЙ 109
 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
 АВТОТЭЭВРИЙН ТӨВИЙН
 ДАРГА
 Т. БАТ-ЭРДЭНЭ

АЖ АХУЙ НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:
 ЗИКҮСОРА ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ
 Б. ДАВААДОРЖ

Хаяг: Улаанбаатар сум, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ойчигийн талбай, 9Б Байр 24 тоот
 Утасны дугаар: 99071519, 86065599
 Цахим хаяг: Aqsoramon@gmail.com

5

Орон нутагтай байгуулсан “Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх гэрээ”



Уурхайн усалгааны дараах байдал
Усалгааны машин усалж байгаа байдал



Өнгөн, шимт хөрсний овоолго

6.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

6.3.1. Хог хаягдлыг түр цэгт хадгалж тогтмол хяналт тавьж ажиллах



Энгийн хог хаягдлыг түр хадгалах цэг, хог хаягдлаа ангилан ялгах хогны сав



6.4. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

6.4.1. Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл

Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу Усны сав газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн E-206-000305 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн “Өехий цагаан” уурхайд 2025 оны ус ашиглуулах гэрээ байгуулсан.

Ус ашиглах дүгнэлт гаргуулсан албан бичиг “Өехий цагаан” уурхайн ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн “Умард говийн гүвээт -халхын дундад Сав газрын захиргаатай 2025 оны 10 дүгээр сарын 02-ны өдрийн 234 тоот дугаартай Ус ашиглах гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шимт хөрсний овоолго хадгалах талбай




Ус ашиглуулах дүгнэлт

Ус ашиглуулах гэрээ

6.4.2. Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих

Нөлөөллийн бүсийн айлуудын ундны усны худгаас дээж авч Хөрс усны “Грийн лаб” лабораторид усны шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээгээр ямар тус худгийн усыг ундны усанд хэрэглэж болно гэсэн дүгнэлт гарсан.



“GREEN LAB”
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ

СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2025.05.15-30
Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: “Эйкусора” ХХК
Холбоо барих дугаар: 99055876
Дээж авсан газар: Улаанбаатар Хот СБД-ийн 1-р хороо Олимп гудамж 9,5 байр 24 тоот
Лабораторийн дугаар: 25/849


Усны химийн шинжилгээний үзүүлэлт

№	Сорилтын үзүүлэлтүүд, хэмжих нэгж	Сорилтын аргын тэмдэглэгээ	Шаардлага MNS 0900:2018	Сорилтын дүн
				1
1	pH	MNS ISO 10523:2001	6.5-8.5	7.49
2	Ерөнхий хатуулаг, мг/элл	MNS ISO 6059:2005	7.0	4.98
3	Кальци, мг/л	MNS 1097:2023	100.0	2.83
4	Магни, мг/л	MNS 1097:2023	30.0	0.121
5	Хлорид, мг/л	MNS ISO 9297:2005	350	2.94
6	Гидрокарбонат, мг/л	MNS 6831:2020	-	54.6
7	Перманганатын исэлдэх чанар, мг/Ол	MNS 6833:2020	5-15	1.67
8	Цахилгаан дамжуулах чанар, µS/cm	MNS ISO 7888:1999	1.0	0.361
9	Хуурай үлдэгдэл, мг/л	MNS 4423:1997	1000	245.0
10	Нитрит, мг/л	MNS 6779:2019	1.0	0.005
11	Нитрат, мг/л	MNS ISO 7890-3:2005	50.0	0.12
12	Темпер, мг/л	MNS 4430:2005	0.3	0.007
13	Аммоний, мг/л	MNS 4428:1997	1.5	0.00

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилган олцуруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
Шинжээч: / Д.Пагмасүрэн /
ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:
Лабораторийн эрхлэгч: Г.Ганчимэг / M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо, Алтайн зүгэмж 5 дөвхөр оффис 2 дөвхөр 243 тоот
Утас/Факс: 72702020, 88950826
E-mail: landowner.torgola@gmail.com





6.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

6.5.1. Кемп болон ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх

Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь сумын нутаг нь монгол орны физик газарзүйн мужлалаар Төв халхын хээрт хамаарна. Энэ бүс нутаг нь талын ландшафттай тул хээрийн амьтны аймаг зонхилдог. Уурхайн кемп орчимд үзэгдсэн амьтдын дийлэнх нь голио, царцаа, нисдэг хар хорхой, үнэг, хярс, алаг даахай зэрэг үзэгдсэн.



Голио



Алаг даахай

ДОЛОО. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

7.1. Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамал тариалах Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний ажлын хүрээнд уурхайн кемпийн орчимд олон наст зүлэг тарьж арчилгаа усалгааг хуваарь гаргаж услах ажлыг хийсэн.



Олон наст зүлэгний хөрс бэлдсэн байдал




Уурхайн кемпийн урд зүлэг ургасан байдал

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

8.1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр


8.1.1. Цаг агаарын улирлын сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах

Уурхайн хэмжээнд тогтмол цаг агаарын 5 хоногийн мэдээг дамжуулж болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлж, хэт хүйтэн нөхцөлд ажилчдыг 1 цаг гадаа 10 минут дулаан газарт байх зарчмыг баримталж ажиллах талаар чиглэл өгч, хэт халуун нөхцөлд өдөрт авах усны хэмжээг 2 дахин нэмэгдүүлж наршихаас сэргийлэх, салхины хэм ихэссэн тохиолдолд өндрийн ажил хийгдэхгүй талаар сануулан арга хэмжээ авч ажиллахад анхаарч байна.



Цаг агаарын 5 хоногийн урьдчилсан мэдээ

8.1.2. Гамшгийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
2024 онд Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төвөөр
Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутагт орших “Өехий цагаан” уурхайн
хэмжээнд тохиолдож болзошгүй гамшиг эрсдлийн үнэлгээг хийлгэсэн.




Эйкүсора ХХК-ийн Өехий цагаан хүрэн нүүрсний уурхайн гамшигийн эрсдлийн үнэлгээ

8.1.3. Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах

“Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 8-р зүйлийн 8.1-д заасны дагуу уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05-р сарын 09-ны өдөр Говьсүмбэр аймгийн Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад С.Энх-Эрдэнээр хянуулан Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан. “Уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан Улаанбаатар хотын Налайх дүүрэгт орших Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Уул уурхайн аврах 09-р ангийн даргын захирагч хурандаа Д.Гантулгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**“ӨЕХИЙ ЦАГААН”-НИЙ ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Гамшгаас хамгаалах төлөвлөгөө -2025

Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө – 2025

2025 онд батлагдсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө, уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөгөөр 2025 оны 5-р дугаар сард Компаний нийт ажилтанд сургалт орсон. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд орсон сайн дурын бүлгэмийн 7 гишүүдийг хамруулан үүрэг чиглэлээр хангаж дасгал сургуулилт, сургалт зааварчилгаа өгсөн.




Аймгийн ОБГ-аас газрын сургалт хариуцсан ажилтан Н.Жавхлант Галын аюулаас сэргийлэх сургалт хийв



Галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилт хийж буй байдал


8.1.4. Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, Гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, Галын аюулгүй

байдлын үндсэн дүрмийг үндэслэл болгон “Галын аюулгүй байдлын журам”-ыг боловсруулан 2025 оны 01-р сарын 12-ны өдрийн “Эйкүсора” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж байна.



Өөхий цагаан уурхайн “Галын аюулгүй байдлын журам”

Уул уурхай, оффис, кемпийн галын аюулгүй байдлын дүгнэлт



Галын хор уурхайн кемпийн дотор талд стандартын дагуу байрлуулж тэмдэглэгээ хийсэн байдал. Нийт 9кг-тай 12ш

“ӨЕХИЙ ЦАГААН”-НИЙ ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Галын иж бүрдэл, Анхны тусламжийн хайрцаг, галын самбар



Уурайн оффис болон амрах байрны өрөөнүүдэд галын дохиолол өгөх төхөөрөмж




Аврах гарын батлагдсан план зураг


8.2. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр

8.2.1. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэнд хяналт тавих


“Эйкүсора” ХХК-ийн Өехий цагаан уурхайн талбайд мөрддөг Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх байнгын комисс байгуулж уурхайн хэмэжээнд гарсан осол, осолд дөхсөн тохиолдлыг судлан бүртгэх журам боловсруулж тайлан хийж тэр төрлийн осол дахин гарахаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.



Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх байнгын комисс байгуулах тухай захирлын тушаал



Осол, осолд дөхсөн тохиолдлыг судлах судалгааны тайлангийн маягт



Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа батлах тухай захирлын тушаал

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

9.1. Ахуйн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр

9.1.1. Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох

Уурхайн үйл ажиллагааны дүнд үүсэж буй хог хаягдлын байгаль орчинд ээлтэй, ангилах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажиллаж байна.

Ахуйн ангилан ялгах хог хаягдлын сав кемпийн хэмжээнд 3 газарт, засварын талбайн хэмжээнд 1 газарт нийт 12 савыг байршуулсан.



Оффисын ангилан ялгах хог хаягдлын сав



Гал тогооны ангилан ялгах хог хаягдлын сав



Энгийн хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах талбай



Энгийн хог хаягдлын 2 жилийн хугацаатай гэрээ


Энгийн хог хаягдлыг тээвэрлүүлж нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэхээр Аймгийн “Тохижилт сүмбэр” ОНӨҮГ-тай гэрээ байгуулан гэрээний хүрээнд төлбөрийг сар бүр хийж байна.

9.2. Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр


9.2.1. Аюултай хог хаягдлыг үүсгэгч болон аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах үйл ажиллагаанг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар, тусгай зөвшөөрөл авах

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг тус тус үндэслэн болгон Говьсүмбэр аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 10-р сарын 13-ны өдрийн 201 тоот албан тоотоор Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг Хог хаягдлын улсын мэдээллийн санд бүртгүүлж Y-002183 дугаар авсан.

Мөн Аюултай хог хаягдлыг хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах үйл ажиллагаа эрхэлдэг “Түмэн эгшиг” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.



Аюултай хог хаягдлын үүсгэгч Улсын бүртгэлийн дугаар



Аюултай хог хаягдлын устгагч компанитай байгуулсан гэрээ



Аюултай хог хаягдлын түр хадгалах талбай

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

10.2. Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээ

ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ
ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
 Утас/Факс: 77278899, 77288899
 E-mail: soil_lab@geo-mongol.mn
 Дугаар: 24/984
 Дүж авсан огноо: 2024 он 05 сарын 13
 Шинжилгээ хийсэн огноо: 2024 он 05 сарын 14-16
 Дүж авсан газрын нэр: Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум, “Экүсора” ХХК
 Координат: 46°18'50.83" 108°28'53.58"
 ИДТ: -
 Дүж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Дойтын булаг” ХХК
 Харилцах утас: 80622694

ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ
ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
 Утас/Факс: 77278899, 77288899
 E-mail: soil_lab@geo-mongol.mn
 Дугаар: 24/985
 Дүж авсан огноо: 2024 он 05 сарын 13
 Шинжилгээ хийсэн огноо: 2024 он 05 сарын 14-16
 Дүж авсан газрын нэр: Говь-Сүмбэр аймаг, Сүмбэр сум, “Экүсора” ХХК
 Координат: -
 ИДТ: -
 Дүж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Дойтын булаг” ХХК
 Харилцах утас: 80622694

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	рН	Динг, %	ЦЭВ, дин	Линг, %	NO ₃ мг/100г	СӨД, %	Шингэгдсэн сүүрвэл м-ж/100гр				Шам тусгайлан замгууд м/100 гр			
										Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13	14				
1	243016	Зүсэл-1	0-20	8.54	0.16	0.353	1.18	2.59	0.32	12.6	4.0	2.1	26				
2	243011	Зүсэл-1	20-40	8.38	0.07	0.142	0.27	0.78	0.16	5.0	7.1	0.8	22				

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	рН	Динг, %	ЦЭВ, дин	Линг, %	NO ₃ мг/100г	СӨД, %	Шингэгдсэн сүүрвэл м-ж/100 гр				Шам тусгайлан замгууд м/100 гр			
										Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13	14				
1	243012	Зүсэл-2	0-20	7.91	0.02	0.053	0.75	2.36	0.00	4.4	2.6	2.4	15				
2	243013	Зүсэл-2	23-33	7.98	0.02	0.056	0.68	3.08	0.00	5.1	4.5	2.0	5				
3	243014	Зүсэл-2	35-45	8.42	0.05	0.101	0.21	1.29	0.16	4.4	4.1	0.9	3				

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширээгүүд, % ширээгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.005-0.001	<0.001	<0.01	
1	243010	Зүсэл-1	0-20	45.7	22.9	9.3	4.4	15.8	5.0	22.2
2	243011	Зүсэл-1	20-40	42.4	28.3	8.7	1.6	14.1	4.9	20.6

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширээгүүд, % ширээгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.005-0.001	<0.001	<0.01	
1	243012	Зүсэл-2	0-20	52.4	31.2	4.3	1.1	6.2	4.8	13.1
2	243013	Зүсэл-2	23-33	34.9	47.5	5.0	2.3	5.7	4.6	12.3
3	243014	Зүсэл-2	35-45	29.6	54.1	2.9	1.2	9.3	2.9	13.4

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Дуно металл мкг/г					
				NI	Ca	Pb /Хар утгагүй	Cu /Зөв	Zn /Дайр	Cr /Хром
1	243011	Зүсэл-1	20-40	5.81	ND	18.61	0.50	75.51	ND
Хүнд металл MNS 5850:2019				150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хөрсний агуулга MNS 5850:2019				1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агуулга MNS 5850:2019				1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Засментаулиг зөвшөөрөх дээж хэмжээ стандарт				MNS 5850:2019					

Жэж: Энэ үнэмжлэлийн гэрэл нь тухайн үеийн дээжний хэмжээг ба хуульчлан гэрээлжээг харуулна.
 Шинжилгээ хийсэн арга стандарт:
 (MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: *[Signature]* Я.Болдбаатар /MS.c/
 Задлан шинжлэгч: *[Signature]* О.Дагвийжамал /MS.c/

Лабораторийн эрхлэгч: *[Signature]* Я.Болдбаатар /MS.c/
 Задлан шинжлэгч: *[Signature]* О.Дагвийжамал /MS.c/

АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

11.1. Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Байгаль хамгаалах ажилд зориулж нийт 45 сая төгрөгийг тушаасан байна.

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information							
ЖурналынJournal No: 006719476254							
Системийн огноо/System Date: 2024.04.19 11:10:06							
Дүр/From	Дансны/Картын дугаар Account/Card number 5125103758	Нэр/Name	ЭЙКҮСОРА	Дүн/Amount	15,000,000.00 MNT	Ханш/Rate	1.00
/ Арван таван сая төгрөг /							
Күт/To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр Bank Name Төрийн Сан	Нэр/Name	15,000,000.00 MNT		1.00	
	Дансны/Картын дугаар Account/Card number 100900013406	БО нөхөн сэргээх баталгаа					

Түлээгээний утга/Transaction description:
БВ-Эйкүсора ХХК рд:5586119 MY-020423

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Bank of Mongolia (BOM) receipt form with fields for Sender's Information, Receiver's Information, and Transaction Details. The amount is 15,000,000.00 MNT.

Байгаль орчны нөхөн сэргээх баталгааны баримт

11.2. Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Эйкүсора” ХХК-ийн Өехий цагаан нүүрсний орд газар дахь ил уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготойгоор боловсруулан “Байгаль орчны үнэлгээний аудитын газраар батлуулав.

БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч. ХАНДСҮРЭН

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ
“ЭЙКҮСОРА” ХХК ЗАХИРАЛ

Б.ДАВААДОРЖ

“ЭЙКҮСОРА” ХХК НИЙ ГОВЬСҮМБЭР АЙМАГ, СҮМБЭР, ШИВЭЭГОВЬ
СҮМДЭЙН НУТАГТ ХЭРЭГЖИХ ӨЕХИЙ ЦАГААН ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-020423
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5586119

ХЯНАСАН:
ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

3. АЗЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
“ЭЙКҮСОРА” ХХК БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

П.ГАНТӨМӨР

2025 ОН

Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөө

